



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН
2017 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТОЙМ**



Агуулга

1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	3
1.1 Зах зээлийн үнэлгээ	3
1.2 Зах зээлийн үнэлгээ(ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн(ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин	4
1.3 Үнэт цаасны зах зээлийн индекс	4
2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД	5
2.1. Хувьцаат компаниуд	5
2.2. Зохицуулалттай этгээдүүд	6
3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ	8
3.1. Хувьцааны арилжаа	8
3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа	9
3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	9
3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	10
4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ТАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС	10
4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд	11

ЗУРАГ

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/.....	3
Зураг 2. Хөрвөх чадварын түвшин	4
Зураг 3. ТОП-20 индекс.....	5
Зураг 4. Хувьцаат компанийн тоо	5
Зураг 5. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/.....	8
Зураг 6. Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь.....	9
Зураг 7. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо	11
Зураг 8. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ	11

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани.....	3
Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо.....	5
Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц.....	6
Хүснэгт 4. Зохицуулалттай этгээдийн тоо.....	6
Хүснэгт 5. Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/.....	7
Хүснэгт 6. Нийт орлого /сая төгрөгөөр/.....	7
Хүснэгт 7. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт.....	8
Хүснэгт 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/.....	9
Хүснэгт 9. ХААБ-ийн арилжааны хэмжээ, эзлэх хувь.....	10

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ


Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, үнэт цаасны арилжааны ДНБ-д эзлэх хувь, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж авч үздэг бөгөөд тухайн улсын хувьд дээрх хөгжлийн үзүүлэлтүүд ямар түвшинд хүрснээс хамаарч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх, хөрөнгө оруулалтын урсгал бий болох, улмаар бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог.

1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн багтаамж, түүний эдийн засгийн өсөлтийг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бөгөөд энэхүү үзүүлэлтийн өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,497.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74.59 тэрбум төгрөг буюу 5.24 хувиар өссөн үзүүлэлт юм. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэхүү өсөлтөд ТОП-20 индексэд багтдаг нэр бүхий таван хувьцааны ханш 235.31, 188.93, 69.32, 56.47, 39.97 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Тайлант хугацаанд нийт зах зээлийн үнэлгээний 90.5 хувийг 30 компани бүрдүүлсэн бөгөөд дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани

№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	ТАВАН ТОЛГОЙ	252.53	16	БИДИСЕК	20.23
2	МИК ХОЛДИНГ	252.45	17	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18.22
3	АПУ	215.46	18	БЭРХ УУЛ	16.01
4	ГОВЬ	101.80	19	БАЯНГОЛ ЗБ	15.26
5	УБ БҮК	52.33	20	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	13.05


6	СҮҮ	47.15	21	ТЕХНИКИМПОРТ	11.70
7	МОНГОЛ ШУУДАН ХК	38.64	22	ГЕРМЕС ЦЕНТР	11.39
8	БАГАНУУР	37.67	23	МАТЕРИАЛИМПЕКС	10.95
9	ШИВЭЭ ОВОО	33.41	24	АТАР ӨРГӨӨ	10.80
10	ГУТАЛ	27.53	25	ХӨХ ГАН	10.12
11	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	26.70	26	СИЛИКАТ	9.50
12	ШАРЫН ГОЛ	23.39	27	МАХИМПЕКС	9.12
13	ТАХЬ КО	23.19	28	АРИГ ГАЛ	8.53
14	ДАРХАН НЭХИЙ	22.66	29	АДУУНЧУЛУУН	6.62
15	ТАЛХ ЧИХЭР	22.21	30	ЖЕНКО ТУР БЮРО	6.39

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

1.2 Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин

2017 оны 2 дугаар улирлын байдлаар ЗЗҮ-г 2016 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ны хэмжээтэй харьцуулахад 6.26 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.11 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулан хөрвөх чадварыг тооцсон дүн 0.48 нэгж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.14 нэгжээр өссөн байна.

Зураг 2. Хөрвөх чадварын түвшин



*2016 оны жилийн эцсийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан дүн


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

1.3 Үнэт цаасны зах зээлийн индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 386.28 нэгжээр буюу 3.1 хувиар өсч, 12,660.44 нэгжид болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 13235.89, доод үзүүлэлт 11972.11, дундаж үзүүлэлт 12573.80 нэгж байна.

Тайлант хугацаанд MSE ALL индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.43 нэгжээр буюу 1.2 хувиар буурч 860.47 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 867.98 нэгж, доод үзүүлэлт 814.51 нэгж, дундаж үзүүлэлт 838.80 нэгж байна.

Зураг 3. ТОП-20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

2.1. Хувьцаат компаниуд

Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 301 компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хорооны зүгээс хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, Хорооны бүртгэлийг бүртгэлийн /listing/ хэлбэрээс зөвшөөрлийн /registering/ хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	“ҮЦТХТ” ХХК	“Монголын хөрөнгийн бирж” ХК	СЗХ
Төрийн өмчит	35	21	31

Төрийн өмчийн оролцоотой	9	16	19
Хувийн өмчит	273	199	251
Нийт	317	236	301

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц

Үнэт цаас гаргагчийн ангилал	2015 он	2016 он	2017-II
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,809,930	4,160,854	4,164,810
Төрийн мэдлийн хувьцаа	2,246,316	2,818,124	2,818,124
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
Нийт	5,085,292	7,008,024	7,011,980
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,558,176	2,212,224	2,212,225
Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,139	5,203	5,598
Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,436,685	12,782,573	12,782,177
Нийт	15,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай ХК	172,753	174,958	214,449.6
Нийт	172,753	174,958	214,449.6

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

2.2. Зохицуулалттай этгээдүүд

Тайлант хугацаанд 61 ҮЦК Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 14 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 15 этгээд тусгай зөвшөөрөлтэй байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 4. Зохицуулалттай этгээдийн тоо

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	14
5	Брокер, дилер	61
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	22
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	15
	Нийт	82
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	15
11	Аудитын компани	44

12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	19

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Мэргэжлийн оролцогчидын өнөөгийн нөхцөл байдал: 2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт ҮЦК-иудын тоо 61 байгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд хангалттай хэмжээнд хүрсэн хэдий ч, санхүүгийн хувьд чадавхтай, үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцдог, холбогдох хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг компаниуд цөөн байгаа тул хөрөнгийн зах зээлийн хөгжлийг цаашид нэмэгдүүлэх, мэргэжлийн оролцогч байгууллагуудыг чадавхжуулах замаар үнэт цаасны арилжааны хэмжээ, хөрвөх чадвар болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай тулгарч байна.

Хүснэгт 5. Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017-II
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	71.6
2	Эргэлтийн бус хөрөнгө	19.4
3	Нийт актив	91
4	Өр төлбөр	21.2
5	Эздийн өмч	69.8
6	Нийт пассив	91

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд салбарын нэгтгэлд хамрагдсан нийт 40 үнэт цаасны компаниас 29 компани алдагдалтай, 11 компани ашигтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан компаниудаас нэр бүхий 5 компани арилжаанд оролцоогүйгээс шимтгэлийн орлого олоогүй байна. Иймд түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал хүлээсэн байна. Мөн нийт зардлын хувьд үндсэн үйл ажиллагааны зардлууд болох ажилчдын зардал, төлбөр, хураамжийн зардал, санхүүгийн зардал, түрээсийн зардлууд өндөр хувьтай байгаа нь ашиг буурахад голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 6. Нийт орлого /сая төгрөгөөр/

№	Орлогын хураангуй тайлан	2016	2017-II
1	Үйл ажиллагааны орлого	5,492.16	2603.712
2	Ногдол ашгийн орлого	493.08	764.9043
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	6,097.59	2933.539
4	Ажиллагчдын цалингийн зардал	2,778.28	1451.541
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	847.70	458.9824
6	Санхүүгийн зардал	588.05	373.2983
7	Бусад зардал	82.37	14.11026
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	641.35	-157.797
9	Бусад ашиг (алдагдал)	-384.05	692.4047
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,134.58	1346.027

11	Орлогын татварын зардал	117.96	152.1333
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,016.61	1193.905

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

3. ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

2017 оны 2 дугаар улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан нийт 512.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 дахин буюу 519.6 хувиар өсчээ. Нийт арилжааны үнийн дүнгийн 2.4 хувь буюу 12.2 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 84.7 хувь буюу 433.9 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, 11.7 хувь буюу 60.1 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, 1.2 хувь буюу 6.0 тэрбум төгрөгийг компанийн өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 7. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт


Үнэт цаасны төрөл		Арилжагдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Алжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	-	-
	Хоёрдогч зах зээл	45.5	12.2
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	4.7	433.9
	Хоёрдогч зах зээл	0.62	60.1
Компанийн бонд	Анхдагч зах зээл	0.06	6.0

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

3.1. Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд нийт 125 удаагийн арилжаагаар 112 компанийн 45.5 сая ширхэг хувьцааг 12.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт 112 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 компанийн үнэт цаасны ханш өсч, 58 компанийн үнэт цаасны ханш буурч, 9 компанийн үнэт цаасны ханш тогтмол байсан. Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 99.06 хувь, үнийн дүнгийн 93.97 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 5. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

Анхдагч зах зээлийн арилжаа: Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 24 удаа явагдаж, 12, 28, 39, 52, 104, 156 долоо хоногийн хугацаатай нийт 4.7 сая ширхэг үнэт цаасыг 433.9 тэрбум төгрөгөөр арилжаад байна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа: ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 620.0 мянган ширхэг үнэт цаасыг 60.1 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Зураг 6. Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Эх сурвалж: “Монголийн хөрөнгийн бирж” ХК

3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд Хорооны 2017 оны 75 дугаар тогтоолоор “МИК Актив арван хоёр” ХХК-ийн 262,445 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгээд байна. 2017 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр 12 удаагийн үнэт цаасжуулалт хийгдсэнээс нийт 403,8 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн байна.

Хүснэгт 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТТТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	96.3	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	67.5	1,135
“МИК актив арван хоёр ТЗК” ХХК	272.3	262.4	4,439
Нийт	2982.9	2890.3	56,627

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны 2 дугаар улирлын байдлаар үндсэн ба хүүгийн төлбөр төлөгдсөн “МИК Актив Нэг” бондоос 136,111 ширхэг, “МИК Актив Хоёр” бондоос 89,496 ширхэг, “МИК Актив Гурав” бондоос 120,283 ширхэг, “МИК Актив Дөрөв” бондоос 174,530 ширхэг, “МИК Актив Тав” бондоос 107,823 ширхэг, “МИК Актив Зургаа” бондоос 86,538 ширхэг, “МИК Актив Долоо” бондоос 90,975 ширхэг, “МИК Актив Найм” бондоос 59,728 ширхэг, “МИК Актив Ес” бондоос 31,669 ширхэг, “МИК Актив Арав” бондоос 12,907 ширхэг, “МИК Актив Арван нэг” бондоос 11,303 ширхэгийг тус тус хасаж, үндсэн бүртгэлд өөрчлөлт оруулсан.

3.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Хөдөө аж ахуйн биржээр дамжин 8 бүтээгдэхүүн арилжигддагаас, тайлант үед нийт 4 төрлийн бүтээгдэхүүн арилжигдсан. Эдгээр нь ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос болон завод ноос (ямааны болон хонины) болно. 2017 оны 2 дугаар улиралд арилжагдсан барааны хэмжээгээрээ ямааны ноолуур хамгийн их буюу 4934 тонн арилжаалагдаж, харин тэмээний ноос хамгийн бага буюу 52 тонн арилжаалагдсан байна. Харин арилжааныхаа дүнгээр мөн ямааны ноолуур 389.3 тэрбум төгрөг буюу нийт арилжааны 98.9 хувийг эзэлсэн бол тэмээний ноос 312.2 сая төгрөг буюу нийт арилжааны 1 хүрэхгүй хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 9. ХААБ-ийн арилжааны хэмжээ, эзлэх хувь

№	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь /арилжааны дүнгээр/
1	Ноолуур	4934	389	79.1
2	Хонины ноос	486.4	0.639	7.8
3	Тэмээний ноос	52	0.312	0.8
4	Ямааны завод ноос	151.39	2.2	2.4
5	Хонины завод ноос	613.2	0.792	9.8
	Нийт	6236.99	393.4	100%


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ТАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээл эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжинд өссөн дүнгээр нийт 893,646 данс, 140,882 холболтын данс нээгдсэн байна. Нийт дансыг бүтцээр нь үзвэл 888,879 дотоодын иргэн, 1,994 гадаадын иргэн, 2,591 дотоодын аж ахуйн нэгж, 182 гадаад аж ахуйн нэгжийн данс тус тус байна.

Тайлант хугацаанд арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалаар нийт 238 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 287 ХК-ийн 760,979 ширхэгхувьцааны өмчлөх эрхийг, бэлэглэлээр давхардсан тоогоор 13 ХК-ийн 119,351 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлэр 64 гүйлгээ хийгдсэн.


Зураг 7. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хэмжээ 0.05 нэгж бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хэмжээ 0.95 нэгж байна.

Зураг 8. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 317 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22.2 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас 29 төрлийн 25.6 сая ширхэг компанийн бонд, 172 төрлийн 10.8 сая ширхэг Засгийн газрын бонд бүртгэлтэй байна. Үүнээс

24 төрлийн 25.3 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан бонд, 92 төрлийн 4.3 сая ширхэг Засгийн газрын бонд нь биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150.0 сая ширхэг хувьцаа, “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн 22.7 сая ширхэг хувьцаа, “Апи ресурс” хаалттай ХК-ийн 2.2 сая ширхэг хувьцаа, “Монгол базальт” хаалттай ХК-ийн 39.4 сая ширхэг хувьцаа төвлөрсөн хадгаламжид тус тус бүртгэлтэй байна. Нийт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй 317 ХК-ийн 22.2 тэрбум ширхэг үнэт цаасны 70.19 хувийг төрийн өмчийн оролцоотой компанийн, 0.13 хувийг орон нутгийн оролцоотой компанийн, 29.68 хувийг төрийн мэдлийн бус буюу хувийн компанийн хувьцаа тус тус бүрдүүлж байна.

--oOo--